

## **Алаг адуун овогт Сандагийн Дуламсүрэн миний амьдралын 61 жилийн намтар, дурсамж**

*Дуламсүрэн миний бие нь 1952 оны хавар Ховд аймгийн Дарви сумын Баясгалантын амны „цагаан чулуут,, хэмээх газар төрсөн гэж аав ээж минь ярьдаг боловч тэр үеийн хүн амын бүртгэл тодорхой бус цаг хугацаа харгалзахгүй төрсөний гэрчилгээ гэж байгаагүйгээс 11 сард төрсөн гэж бүртгээгдсэнээр одоог хүрчээ.*

Би 13 хүүхэдтэй айлын 7 дахь нь буюу ах нарынхаа хүсэж мөрөөдөж байснаар аргалын хуурай нойтонг мэдрэх анхны охин дүү нь болж төрсөн аав, ээжийн амин эрдэнэ байлаа. 8 нас хүртэлээ аав ээждээ эрхэлж, аргал түлш түүх, хонь хурга эргүүлэх, ямаа саах зэрэг ажлуудыг төвөггүй хийдэг хүүхэд байсан гэж аав ээж минь ярьдаг. 8 нас хүрсэнээр Дарви сумын бага сургуульд орж малчин айлын хүүхэд учраас том ахындаа суудаг байв. Гэр орноосоо хол байж үзээгүй байсан учир гэрээ маш их санадаг, шөнө орондоо уйлдаг, хаяа аав ээжийгээ ирээд буцахад нь гэрийнхээ гадаа үлдэж, явсан зүг рүү нүдээ чилтэл харж /Хүргэн хүү киноны Бумаа эмгэн шиг / суусаар далд орохоор нь гэртээ ордог тийм хариугүй хүүхэд байж билээ.

Бага сургуулийг 1964 онд „Онц,, дүнтэй 5 онцын эзэн төгсч байлаа. Ингээд 1964-1968 онд Ховд аймгийн Зэрэг сумын 8 жилийн дунд сургуульд шилжин суралцсан. 8 жилийн сургуульд суралцахаар явахдаа бага сургуульд орж байснаа бодоход том болсон том ангийн сурагч болж байгаа гэсэн утгаараа өөр болсон байсан. Гэхдээ....л гэрээ санадаг, уйлдаг уяхан зан минь хэвээрээ.... одоо ч тэр зан хэвээрээ шүү төрөлхийн юм байлгүйдээ.

8 жилийн сургуульд суралцаж байх хугацаанд дурсамжтай зүйлүүд бас байсан. Ховд аймгийн Зэрэг сум нь эргэн тойрон маш өндөр уулуудтай хаварт маш их хүчтэй шуурга шуурдаг. Уул хүнгэнээд хуй босвол заавал шуурга шуурдаг. Шуурга шуурсан үед байшингуудын дээвэр хуурдаг, хашаа хаалга нурдаг, цонхны шил эрээн цоохор болтолоо хонхойдог. Шуурга болсоны дараа хүүхдүүдэд нурсан хашаа хаалга босгох, хийссэн дээврийн төмөр цуглуулах гэх мэт маш их ажил гардаг байв. Нэг удаагийн шуурганаар миний хичээлдээ өмсдөг хошмогтой хөвөнтэй дээл /тэр үеийн форм/-ийг хэдүүлээ нөмөрч яваад шуурганд дийлэлгүй хийсгээд дараа нь төмөр цуглуулахдаа хайгаад ч олоогүй. Тэр үед бидэнд мөнгө төгрөг ховор ганц хоёр төгрөг байвал түүгээрээ хатсан цагаан пераник авна түүнийгээ хоёр чулууны хооронд хагалж иднэ мөн арай олон тоотой үзэм авч бие биеэндээ тоолж зээлдэг эргүүлж авдаг тийм л түүхтэй хүүхдүүд байсандаа. Бас хавар болоход дотуур байр нь маш их чийгтэй учраас хүүхдүүд маань чийгэнд хөл гуя нь хөх эрээн болж явж чаддагүй болдог үе ч байсан. Энэ нөхцөл байдалд бид шантарч оргож босгож байгаагүй.

Би 8 дугаар анги төгсөхдөө онц төгсөөгүй ч 10 жилийн сургуульд дэвшин суралцах боломжтой байсан. Гэвч өөрийн хүсэлтээр Улаанбаатар хотод ах нар дээрээ ирэх сонирхолтой байсан учир Худалдааны техникумын төлөвлөгөө эдийн засгийн ангид орж суралцах болсон.

Ингээд 1968 онд Улаанбаатар хотын худалдааны техникумд орж суралцаад 1971 онд төгсөж Худалдаа бэлтгэлийн яамны томилолтоор Төв аймгийн Худалдаа бэлтгэлийг удирдах газар хуваарилагдан ирж төлөвлөгөөний хэлтэст төлөвлөгч -эдийн засагчаар ажиллаж ажлын гараагаа эхлэж байлаа. Манай ангийн төгсөлтийн өмнөх дадлага Төв аймагт хийгдсэн ба Би Мөнгөнморьт сумын Худалдаа бэлтгэлийн ангид 45 хоног дадлага хийсэн нь Төв аймагт хуваарилагдах суурь нь болсон байхаа.

За ингээд Төв аймгийн Бараа татан авалт, борлуулалт, нийтийн хоол, ноос, ноолуур, түүхий эд бэлтгэлийн 70 гаруй нэр төрөл/ ямааны сахал сүүлнээс эхлээд үнэг, хярс, ятуу шувуу ...гэх мэт /-ийн төлөвлөгөөг Хэлтсийн дарга /Нямсүрэн гэж алаг нүдэн сайхан хүүхэн/-тайгаа хамтран 29 сумаар, жилээр, улирлаар, сараар төлөвлөж гүйцэтгэлийг долоо хоногоор гаргадаг маш их ачаалалтай ажилд ёстой л нойр хоолоо хасан залуу насны аагаар гүйцэтгэж байсан юм шиг одоо санагддаг. Тэр үед утас холбоо одоотой адилгүй, техник хэрэгсэл нь орос, хятад сампин, гараар эргүүлдэг арифмометр л байсандаа. Мэдээ сумдаас утсаар авна. Байна уу байна уу гэсээр нэг юм авна авсаныгаа нэгтгээд өнөө олон нэрээрээ сумдаараа төлөвлөгөөний биелэлтийн хувийг өнөө л эргүүлдэг машинаараа гаргана. Гаргасаны дараа /А-3-ын цаасаар 10-аад хуудас/ сумын нэртэй цаасан дээр 4 хувь хортой цаас хийж хортой харандаагаар хуулж 8 хувь олшруулж аймгийн товчоо захиргааны гишүүд, статистикийн хэлтэст танилцуулдаг байлаа.

1978 онд худалдааны салбарын мэдээлэл аймгийн захиргаанд шилжиж мэдээллэлээ дагаж статистикийн товчоо байхад нь ирж ажилласан. Энд ирсэн нэг ололттой тал нь төлөвлөлт хийхээ больсон, мөн хортой цаасан дээр хуулахаа больж бичээчээр бичүүлж радтороор олшруулдаг болсондоо.

Энэ үеэс улс орны хөгжил, техникийн дэвшил ололт амжилт сайжирч ажиллах нөхцөл бололцоо жил ирэх дутам дээшилсээр одоогийн энэ сайхан хөгжилд хүрсэн. Улсад ажилласан 40 гаруй жилийн хугацаанд ажил амьдралд олон сайхан дурсамжтай үйл явдал тохиолдож байсан. Заримыг дурдвал:

Ажлын маань анхны гараа ХБУГ-рын дарга Гончиг, Төлөвлөгөөний хэлтсийн дарга Нямсүрэн нар 7 жилийн хугацаанд намайг асар их дадлага, туршлага, хатуужил, тэвчээртэй болгож өгсөн. Би тэр үед шинэ ирсэн газартаа дасаж чаддаггүй нэг хэсэгтээ л хуучин өрөөндөө очиж ажлаа хийдэг байсан.

Аймгийн Ардын Депутатын Хурлын Гүйцэтгэх Захиргааны Статистикийн товчоонд ирж ажилласан нь надад мөн л олон сайхан дадлага туршлагатай хүмүүстэй учруулж өгсөн. Тэр үед ажиллаж байсан хэлтсийн дарга Л.Нацагдорж, ахлах мэргэжилтэн Ц.Бямбаа, мэргэжилтэн С.Амарбат, Д.Аюуш, Хөвсгөл аймгийн статистикийн хэлтсийн мэргэжилтэн Даваахүү, Завхан аймгийн статистикийн хэлтсийн мэргэжилтэн Базарсад гээд олон хүний туршлагыг эзэмшиж ажиллаж байсан.

1980-1990 онд хариуцсан салбарын мэдээллийн үнэн зөвийг орон нутагт очиж хянаж шалгах ажил их хийгддэг байсан. Жишээ нь: Ноос, ноолуур, арьс шир, ангийн үсний мэдээллийг шалгана гэхэд Худалдаа бэлтгэлийн ангийн бэлтгэлийн эрхлэгчийн орлогын падааныг нэг бүрчлэн түүж дүнг гарган мэдээтэйгээ тулгадаг бараа борлуулалтыг ч ялгаагүй тэгж л шалгадаг байсан тэгэхэд 100 гр-аас 1 кг юмуу 1 ширхэгээс илүү зөрүү гардаггүй байсандаа. Энэ нь мэдээлэл маш нарын үнэн зөв гардаг байсны баталгаа юм.

Ийм үнэн зөв мэдээлэл гаргах асуудлыг сумын орлогч дарга хариуцдаг байсан ба Жаргалант, Сүмбэр, Эрдэнэсант, Батсүмбэр, Баян, Дэлгэрхаан, Баянжаргалан сумдын орлогч дарга Баярхүү, Пагам, Чүлтэм, Алтанхүү, Доржсүрэн, Жадамбаа, Дамдинпүрэв зэрэг олон хүнийг одоо ч дурсахад таатай байдаг.

40 гаруй жил ажиллахдаа үндсэн ажлаасаа гадна олон нийтийн ажил хурал цуглаан, лекц дугуйлан, сургалт сурталчилгаанд тогтмол оролцож, ёслол хүндэтгэлийн үйл ажиллагаанд хүндлүүлж байсан бол, хэлтсийн нярав, бичиг хэрэг бичээч, архивч, хүлээн авалтын ресепчин,/дүүриймаа/ зэрэг ажлуудыг боломжийн хэмжээнд хийж гүйцэтгэж байсандаа.

Харин өөрийнхөө муугаас дээд мэргэжил гэдгийг эзэмшиж чадаагүй хүндээ. 2 ч удаа шалгалтанд орж босго оноо гэдэгт нь хүрээгүй. Сүүлийн шалгалтанд орох

боломжтой байсан боловч хамт орсон нөхөр маань 1 нэг бодлогыг бодож бие биеэндээ дамжуулах төлөвлөгөөтэй орсон чинь миний дамжуулсан материалыг бид 2-ын дунд эгнээд суусан Мөнхжаргал /мөрөн дэлгүүрт худалдагч байсан/ замаас нь авч өөрөө хуулаад нөгөө нөхөрөөс ирэх материалыг бас авч хуулаад тэр нөхөр шалгалтанд тэнцэж бид 2 хасагдаж байж билээ.

Би дээд сургууль төгсөөгүй ч ҮСГ, Статистикийн хэлтсийн хамт олны дэмжлэгээр Монгол, Орос, Хятад, Япон орнуудад мэргэжил дээшлүүлэх, эзэмших курс дамжаанд суралцаж өөрийн хариуцан гүйцэтгэж байсан ажлыг зохих хэмжээнд гүйцэтгэсэн гэж төр засаг, газар хэлтэс маань Хөдөлмөрийн гавъяаны Улаан тугийн одонгоос доошоо бүхэл шатны шагнал урамшилыг хүртээсэн. Үүгээрээ би хамт олон, үр хүүхэд, хань ижил, аав ээж, ах дүү нартаа бахархагдаж ирсэндээ.

Би өөрийнхөө мэргэжил, ажиллаж байсан ажил мэргэжил, алдар гавъяагаа тодорхойлвол дараахи хүснэгтүүдээс харж болно.

**Мэргэжил:** Төлөвлөгч -эдийн засагч

### **Ажиллаж байсан газар:**

№	Ажлын газрын нэр	Хугацаа	Эрхэлсэн ажил
1.	Төв аймгийн Худалдаа бэлтгэлийг удирдах газарт	1971-07-19 1978-01-20	Төлөвлөгч Эдийн засагч
2.	Аймгийн АДХ-ын гүйцэтгэх захиргааны статистикийн товчоонд	1978 -1990	Статистикч-эдийн засагч
3.	Аймгийн статистикийн хэлтэст	1990-2005	Статистикч-эдийн засагч
4.	Аймгийн статистикийн хэлтэст	2005-2011	Ахлах статистикч
5.	Тус хэлтэст гэрээт ажилтан	2011 оноос одоог хүртэл	Судлаач ажилтан

### **Шагнагдаж байсан шагналууд:**

№	Шагналын нэр	Хэдэн онд	шагнуулах үндэслэл
1.	Алтан гадас одон	2003-06	он удаан жил үр бүтээлтэй ажилласан
2.	Хөдөлмөрийн гавъяаны Улаан тугийн одон	2008-11	он удаан жил үр бүтээлтэй ажилласан
3.	Ардын хувьсгалын 60 жилийн ойн медаль	1981-07	он удаан жил үр бүтээлтэй ажилласан
4.	Ардын хувьсгалын 70 жилийн ойн медаль	1991-07	он удаан жил үр бүтээлтэй ажилласан
5.	Ардын хувьсгалын 80 жилийн ойн медаль	2001-07	он удаан жил үр бүтээлтэй ажилласан

6.Ардын хувьсгалын 90 жилийн ойн медаль	2011-07	он удаан жил үр бүтээлтэй ажилласан
7. Төв аймаг байгуулагдсаны 90 жилийн ойн медаль	2013-07	он удаан жил үр бүтээлтэй ажилласан
8.Бүртгэл, статистикийн тэргүүний ажилтан тэмдэгээр	1993-06	бүртгэл, статистикийн ажилд үр бүтээл гарган ажилласан
9.Төрийн захиргааны тэргүүний ажилтан тэмдэгээр	2009-10	Төрийн захиргааны албанд үр бүтээл гарган ажилласан
10. Монгол ардын намын тэргүүний ажилтан тэмдэгээр	2013-07	Монгол ардын намд оруулсан хувь нэмрийг үнэлж\
11. ҮСХ-ны дурсгалын гэрчилгээ	2001-07	он удаан жил үр бүтээлтэй ажилласан учир хүндэт дэвтэрт бичигдсэн
12.V,VI,VII таван жилийн гавшгайч	1975, 1981, 1986	хөдөлмөрийн амжилт гаргасан

Албан ёсны статистикийн үйл ажиллагааны орон нутгийн түвшинд тавигдсан зорилт, чиг үүргийг мэргэшлийн түвшинд эрхлэн гүйцэтгэж, статистикийн үзүүлэлтийн системийг боловсронгуй болгон мөрдүүлж, үр бүтээл гарган мэдээллийн үнэн зөв, бодит шуурхай байдлыг хангахад өөрийн санаачлага, мэргэжлийн ур чадварыг эзэмшин ажиллаж байв.

Статистикийн албанд ажиллах хугацаандаа үе үеийн статистикийн албаны өмнө тавигдсан зорилт чиг үүргээ мэргэжлийн түвшинд тогтмол биелүүлж ирсэн. Ялангуяа 1990 оноос статистикийн үзүүлэлтийн системийг зах зээлийн зарчимд шилжүүлэх ажлыг аймаг, орон нутгийн түвшинд нэвтрүүлэх ажилд чухал үүрэг гүйцэтгэсэн гэж үздэг. Тухайлбал: ДНБ-ийг тооцох, олон улсын эдийн засгийн стандарт ангиллыг нэвтрүүлэх, үнийн индексийг болон инфляц тооцох, аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний ангиллыг нэвтрүүлэх, статистик бүртгэлийг компьютерт боловсруулах ажлуудыг анх санаачлан хэрэгжүүлсэн.

Статистикийн тухай хууль, төр засгийн газрын шийдвэр болон ҮСГ-аас баталсан мэдээ тайлан, тооллого, судалгааг албан ёсны статистикийн мэдээллийн түвшинд аймгийн хэмжээнд бие даасан хараат бус зарчмаар эрхлэн явуулах, эдийн засаг, нийгмийн амьдралын бодит байдлыг статистик аргаар судлан, нутаг дэвсгэртээ байгаа өмчийн бүх төрлийн статистикийн мэдээлэгчдээс мэдээллийг хугацаанд нь гаргуулан авч нэгтгэн ҮСГ-т мэдээлэх, танилцуулга дүгнэлт хийж аймгийн удирдлага, иргэдийг мэдээллээр үйлчлэх, хэвлэн нийтлэх, мэдээллийн сан байгуулах үүргээ шаардлагын биелүүлж байсан.

Аж ахуйн нэгжүүдээс гарах албан ёсны статистик мэдээний графикийг оны эхэнд шинэчлэн заавар маягтын хамт хүргүүлэн мөрдөн ажилласнаар хариуцан гаргадаг мэдээ, тайлангийн ирц, гаргалтын чанар, хамралтанд байнга ахиц гарч тасалдал,

хожимдолгүй гаргаж хэвшүүлсэн. Мөн аймгийн хэмжээний аж үйлдвэр, барилга, орон сууц нийтийн аж ахуй, худалдаа, нийтийн хоол, үнэ, үнийн индекс, олон нийт бие хүнд үзүүлэх үйлчилгээний салбаруудын 370-465 аж ахуйн нэгжүүдийн тайлан тэнцлээс дотоодын нийт бүтээгдэхүүн, үндсэн ба эргэлтийн хөрөнгө, хөрөнгө оруулалт, цалингийн сангийн судалгаа зэргийг 1996 оноос эхлэн ҮСГ-аас баталсан шинэ аргачллын дагуу жил бүр тооцож боловсронгуй болгож, аймгийн түвшинд үндэсний тооцооны системийг нэвтрүүлэх, статистикийн олон улсын түгээмэл арга зүйг эзэмших чиглэлээр ажиллаж, эдгээр судалгаанууд нь удирдлагын шийдвэр гаргах, бодлого боловсруулах, хөтөлбөр хэрэгжүүлэх үндсэн суурь материал болж чадсанд оршино.

Бүртгэл-статистик-мэдээллийн ажилд орчин үеийн персональ компьютерийг ашиглах ажлын аймгийн анхдагчийн нэг болж хариуцсан салбарын бүх мэдээлэл, судалгааг 1990 оноос *тоон* болон *үсгэн* мэдээлэл боловсруулж, шалгаж, үр дүнгийн хүснэгт хэвлэж авах зориулалттай MSDOS системийн орчинд ажилладаг SC4, EDIT зэрэг програмуудыг; 1995 оноос WINDOWS-3.11; 95; 97; 2000 системийн орчинд ажилладаг WORD, EXCEL, POWER POINT, ACCESS зэрэг хэрэглээний програмуудыг үе шаттайгаар, эрэмбэ цэгцтэй, богино хугацаанд эзэмшснээр жилийн эцсийн болон улирал, саруудын мэдээ, тайлан, судалгааг өнгө үзэмж дүрслэл сайтай боловсруулан хэрэглэгчид үйлчилж мэргэшсэн юм.

2001 оноос статистикийн бүтээгдэхүүн үйлчилгээг цаасгүй технологид шилжүүлэх чиглэлээр ажиллаж хариуцсан салбарын мэдээллийг статистикийн хэлтсийн WEB сайтад байрлуулж хэрэглэгчид хурдан шуурхай үйлчилдэг болсон. \

1999 оноос хойших төрийн захиргааны албан хаагчийн үйл ажиллагааны мэргэжлийн төвшний жилийн эцсийн үнэлгээгээр 7 жил дараалан “А” үнэлгээтэй дүгнэгдэж бүх шатны мөнгөн урамшууллаар шагнагдсан.

1979, 1989, 2000, 2010 оны хүн ам, орон сууцны улсын тооллогууд, 1998, 1999, 2003, 2004, 2005, 2010 оны хүн амын нөхөн үржихүйн эрүүл мэндийн, ажил эрхлэлтийн, хүүхэд-хөгжил, хөдөө аж ахуйн, өрхийн нийгэм эдийн засгийн түүвэр судалгаануудыг аймгийн хэмжээнд зохион байгуулж явуулахад оролцож тооллого, судалгааны ахлагч, тоологчоор идэвхитэй ажиллан анхдагч мэдээллийг үнэн зөв, алдаа мадаггүй бүрдүүлэн боловсруулж графикт хугацаанд нь чанарын өндөр төвшинд холбогдох материалыг тушааж байв.

Статистикийн ажил үйлчилгээг онлайн хэлбэрт шилжүүлж, хэрэглэгчид үйлчлэх ажлуудыг хэрэгжүүлж 42 жил тасралтгүй ажиллахдаа зөвхөн бүртгэл статистикийн ажлыг дагнан гүйцэтгэж ирсэн.

Албан ёсны статистикийн үйл ажиллагааны орон нутгийн түвшинд тавигдсан зорилт, чиг үүргийг мэргэшлийн түвшинд эрхлэн гүйцэтгэж, статистикийн үзүүлэлтийн системийг боловсронгуй болгон мөрдүүлж, мэдээлэлд аж ахуйн нэгж, албан газруудыг хамруулах, мэдээллийн үнэн зөв, бодит шуурхай байдлыг хангахад өөрийн санаачлага, мэргэжлийн ур чадварыг эзэмшин ажиллаж байгаа гэж боддог.

Дурсамж бичсэн :

С,Дуламсүрэн

2013-11-30